




ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХӨА-2022/18/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

https://audit.mn/?page_id=579

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	11
3.5.3 Авлага.....	11
3.5.4 Урьдчилгаа.....	6
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	11
3.5.6 Бараа материал.....	11
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	12
3.5.8 Өр төлбөр.....	12
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
3.5.10 Орлогын данс.....	13
3.5.11 Зардлын данс.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
3.7 Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	16
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	16
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	16
4. Менежментийн захидал.....	16
4.1 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал	16
4.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	16
4.3 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудал.....	17
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	Error! Bookmark not defined.



ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ЦЭРЭН-ОЧИР ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.25 № 01/299
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төсвийн төвлөрүүлэн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Цагааннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсөв, санхүүгийн хувьд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх, үүрэг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.



Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	671,762.1	953,808.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	189,072.4	399,121.1
33	АВЛАГА	121,986.5	114,999.0
35	БАРАА МАТЕРИАЛ	360,703.1	439,688.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,779,151.1	4,245,148.7
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	8,333.3	1,666.7
37300	Урт хугацаат зээл	8,333.3	1,666.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,770,817.8	4,243,482.0
39200	Биет хөрөнгө	3,528,140.2	3,994,450.9
39300	Биет бус хөрөнгө	242,677.6	249,031.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,450,913.2	5,198,957.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	348.1	1,261.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	348.1	1,261.5
41300	Өглөг	348.1	1,261.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,450,565.1	5,197,695.6
51	Засгийн газрын хувь оролцоо	4,450,565.1	5,197,695.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,234,061.4	1,234,061.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,143,593.0	2,943,282.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,072,910.7	1,020,352.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,450,913.2	5,198,957.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,650,790.7	3,403,377.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,530.8	81,760.6
110	Орлогын албан татвар	20,275.4	32,482.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	20,275.4	32,482.4
113	Хөрөнгийн албан татвар	630.0	650.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	30,625.4	48,628.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	264,522.6	778,014.6
120	Нийтлэг татварын бус орлого	264,522.6	778,014.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,334,737.3	2,543,602.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,410,780.0	2,642,415.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,410,780.0	2,642,415.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,285,069.7	2,528,460.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,510,811.9	1,553,217.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,343.4	204,167.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,542.4	117,591.5
2104	Хангамж, бараа материалын зардал	81,697.6	120,995.0
2105	Нормативт зардал	99,834.0	222,192.3



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,455.6	23,196.7
2107	Томилолт, зочны зардал	4,853.8	5,045.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,449.0	18,710.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	281,082.0	263,343.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,710.3	113,955.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	240,010.7	760,961.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	944.7	13,831.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	239,066.0	747,130.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,213,564.9	4,213,564.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,065.8	-2,065.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,211,499.1	4,211,499.1
9	Тайлант үеийн үр дүн	239,066.0	239,066.0
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,450,565.1	4,450,565.1
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,450,565.1	4,450,565.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	52,558.4	52,558.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,503,123.6	4,503,123.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-52,558.4	-52,558.4
19	Тайлант үеийн үр дүн	747,130.5	747,130.5
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,197,695.6	5,197,695.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,425,360.3	2,645,116.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	51,530.8	81,760.6
110	Орлогын албан татвар	20,275.4	32,482.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	20,275.4	32,482.4
113	Хөрөнгийн албан татвар	630.0	650.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	30,625.4	48,628.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,447.3	5,078.0
1181	Газрын төлбөр	700.2	2,287.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	25,477.9	41,262.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,642.1	41,335.7
120	Нийтлэг татварын бус орлого	38,642.1	41,335.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,335,187.3	2,522,020.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,205,815.8	2,316,114.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,205,815.8	2,316,114.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,080,106.4	2,202,079.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,508,282.5	1,552,527.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	197,507.1	206,685.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,835.7	103,694.5



2104	Хангамж, бараа материалын зардал	82,649.6	118,192.1
2105	Нормативт зардал	116,272.0	138,115.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,272.1	33,389.7
2107	Томилолт, зочны зардал	4,900.3	4,872.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,085.3	20,740.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,301.9	23,860.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,709.3	114,035.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	219,544.6	329,001.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	101,951.2	118,953.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,951.2	118,953.2
2200	Дотоод эх үүсвэрээр	101,951.2	118,953.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-101,951.2	-118,953.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-20,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	97,593.4	210,048.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,479.1	189,072.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189,072.4	399,121.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(сая төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,627,117.00	2,326,082.52	301,034.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,418,745.50	2,310,782.52	107,962.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,347,475.60	2,241,149.92	106,325.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,543,140.90	1,514,611.79	28,529.11
210101	Үндсэн цалин	1,128,648.30	1,141,701.77	-13,053.47
210102	Нэмэгдэл	301,920.70	286,656.32	15,264.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,500.00	4,657.24	-157.24
210104	Урамшуулал	81,197.20	58,331.73	22,865.47
210105	Гэрээт ажлын хөлс	26,874.70	23,264.73	3,609.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,562.90	201,430.51	8,132.39
210201	Тэтгэврийн даатгал	148,727.70	141,446.99	7,280.71
210202	Тэтгэмжийн даатгал	15,208.80	15,069.64	139.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,167.10	12,595.49	-428.39
210204	Ажилгүйдлийн даатгал	3,041.80	2,929.75	112.05
210205	Эрүүл мэндийн даатгал	30,417.50	29,388.64	1,028.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,313.60	103,694.48	17,619.12
210301	Гэрэл, цахилгаан	17,888.00	17,174.34	713.66
210302	Түлш, халаалт	101,625.60	85,328.14	16,297.46
210303	Цэвэр, бохир ус	1,800.00	1,192.00	608.00
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	119,347.30	116,849.46	2,497.84
210401	Бичиг хэрэг	6,083.80	6,151.46	-67.65
210402	Тээвэр, шатахуун	50,694.60	52,601.17	-1,906.57
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,643.80	6,441.43	1,202.37
210404	Ном, хэвлэл	1,602.20	485.70	1,116.50



Дархан-Уул сумын төсвийн төсвөөс хийгдсэн ажлын төсвийн гүйцэтгэлд хийгдсэн ажлын үр дүн

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,493.00	2,246.40	246.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,829.90	48,923.31	1,906.60
2105	Нормативт зардал	143,527.80	129,549.01	13,978.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,145.50	25,145.50	0.00
210502	Хоол, хүнс	107,327.40	94,848.61	12,478.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,054.90	9,554.90	1,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	143,057.40	125,972.20	17,085.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,736.40	46,736.40	0.00
210602	Тавилга	50,600.00	47,300.00	3,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	662.20	662.00	0.20
210604	Урсгал засвар	45,058.80	31,273.80	13,785.00
2107	Томилолт, зочны зардал	7,051.50	4,712.50	2,339.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	7,051.50	4,712.50	2,339.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,440.30	22,256.17	10,184.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,091.00	18,366.04	8,724.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,595.00	1,830.00	765.00
210803	Даатгалын үйлчилгээ	337.80	208.90	128.90
210804	Тээврийн хэрэгслийн татвар	426.00	270.96	155.04
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	204.00	55.00	149.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700.00	700.00	0.00
210807	Газрын төлбөр	400.00	138.77	261.23
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	686.50	686.50	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,033.90	22,073.80	5,960.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,662.80	13,462.80	5,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,371.10	8,611.00	760.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,269.90	69,632.60	1,637.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	71,269.90	69,632.60	1,637.30
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500.00	384.00	116.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,983.90	24,462.60	1,521.30
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,336.00	42,336.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,450.00	2,450.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	166,071.50	15,300.00	150,771.50
223001	Бусад хөрөнгө	166,071.50	15,300.00	150,771.50
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	42,300.00	0.00	42,300.00
230001	Эргэж төлөгдөх зээл	42,300.00	0.00	42,300.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,627,117.00	2,494,631.47	132,485.53
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,893,557.80	1,872,554.94	21,002.86
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,760,486.30	1,739,483.44	21,002.86
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	133,071.50	133,071.50	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	589,761.40	563,996.22	25,765.18
320001	Орон нутгийн төсвөөс	589,761.40	563,996.22	25,765.18



33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,622.70	19,617.57	5.13
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,622.70	19,617.57	5.13
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	124,175.10	38,462.74	85,712.36
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.00	36,326.19	3,673.81
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400.00	2,136.55	263.45
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	81,775.10	0.00	81,775.10
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	101,169.61	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	269,718.57	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(сая төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,359.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,359.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,934.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,915.83
210101	Үндсэн цалин	11,799.80
210104	Урамшуулал	26,116.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,255.44
210201	Тэтгэврийн даатгал	3,560.10
210202	Тэтгэмжийн даатгал	438.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	253.10
210204	Ажилгүйдлийн даатгал	329.67
210205	Эрүүл мэндийн даатгал	673.74
2104	Хангамж, бараа материалын зардал	4,768.32
210401	Бичиг хэрэг	625.00
210402	Тээвэр, шатахуун	1,765.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,378.31
2105	Нормативт зардал	9,766.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,766.94
210502	Хоол, хүнс	2,000.00
2107	Томилолт, зочны зардал	160.00
210702	Дотоод албан томилолт	160.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,928.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,928.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,139.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	857.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	282.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,425.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,320.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	120.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	105.00



213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	105.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,559.53
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,559.53
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	378.50
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,378.29
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,164.53
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	52,938.20
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,200.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Цэрэн-Очир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд гарсан алдаа, зөрчил, төсвийн төлөвлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 14-өөс 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Л.Мандахнаран хариуцан гүйцэтгэж, ахлан аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хянаж, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар баталгаажуулж ажиллаа.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт Цагааннуур сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй жигд хүргэх замаар сумын нийгэм эдийн засгийн хөгжлийг хангах” эрхэм зорилгоо дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.



Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу 2019 онд батлагдсан ба аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тус бодлогын баримт бичигт тусгасан хууль, журам заавруудад өөрчлөлт орсон тул бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүү тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу мөр, мөрөөр нэгтгэж бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,316.1 сая төгрөгийн 1.5 хувь буюу 34.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 80 хувиар буюу 27.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тодорхойлох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 189.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 399.1 сая төгрөг болж 210.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
Банканд байгаа бэлэн мөнгө	189.1	399.1	210.0
Дүн	189.1	399.1	210.0
Үүнээс: Байгууллагаар харуулбал			
Орон нутгийн ерөнхий орлого	87.9	128.2	40.3
Сум хөгжүүлэх сан	60.4	98.8	38.5
Орон нутгийн хөгжлийн сан	40.8	158.6	117.8
Эрүүл мэндийн төв	0.0	13.5	13.5
Нийт дүн	189.1	399.1	210.0

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 14.9 сая төгрөгөөр давж биелсэн, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журам өөрчлөгдөж шинээр зээл олгохгүй байгаа, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд хойшлогдож санхүүжилт олгогдоогүй нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 210.0 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.



Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 399.1 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:
 Эрүүл мэндийн төв нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 12.3 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 1.2 сая төгрөг, нийт 13.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй нь "Төсвийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалттай нийцэхгүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 122.0 сая төгрөг 115.0 сая төгрөг болж 7.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт/+, -/
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	0.0	0.0
Сум хөгжүүлэх сан	121.6	90.4	-31.2
Эрүүл мэндийн төв	0.0	23.7	23.7
ЕБС	0.2	0.7	0.5
Хүүхдийн цэцэрлэг	0.1	0.2	0.1
Нийт дүн	122.0	115.0	-7.0

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:
 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журам өөрчлөгдөж шинээр эзэл олгохгүй байгаа нь авлага буурахад гол нөлөөг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн төв нь цар тахлын үед үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний ЭМД-аас авах 23.7 сая төгрөгийн авлага үүссэн байна. Уг авлага 2022 оны 01 дугаар сард төлөгдсөн байна.

3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны эхний үлдэгдэл 8.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.7 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр буурсан нь Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлттэй холбоотой байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 360.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 439.7 сая төгрөг болж, 79.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	51.5	43.4	-8.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3.0	3.0	0.0
Соёлын төв	23.9	25.2	1.3
Ерөнхий боловсролын сургууль	153.6	180.7	27.1
Хүүхдийн цэцэрлэг	73.1	72.9	-0.2
Эрүүл мэндийн төв	55.7	114.6	58.9
Нийт дүн	360.7	439.7	79.0

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайланд онд цар тахлын эсрэг үйл ажиллагаатай холбоотойгоор Эрүүл мэндийн төв 153.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан нь бараа материалын дансны үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна



Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,770.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,243.5 сая төгрөг болж 472.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт/-/
Засаг даргын Тамгын газар	379.3	419.2	39.9
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	29.4	29.1	-0.3
Соёлын төв	54.9	62.2	7.3
Ерөнхий боловсролын сургууль	2,491.9	2,886.6	394.7
Хүүхдийн цэцэрлэг	314.6	367.6	53.0
Эрүүл мэндийн төв	500.5	478.8	-21.7
Нийт дүн	3,770.8	4,243.5	472.7

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайланд онд сумын ЕБС 399.0 сая төгрөгийн барилга, байгууламж хүлээн авсан нь үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдэхэд гол нөлөөг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.3 сая төгрөг болж 0.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засаг даргын Тамгын газар	0.0	0.0	0.0
Ерөнхий боловсролын сургууль	0.2	1.1	0.9
Хүүхдийн цэцэрлэг	0.2	0.2	0.0
Нийт дүн	0.4	1.3	0.9

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүүхдийн цэцэрлэг, ЕБС нийт 1.3 сая төгрөгийн өглөгтэй байна. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөртэй холбоотой акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Өр, төлбөртэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,450.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,197.7 сая төгрөг болж 747.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,234.1	1,234.1	0.00
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	0.00	0.00
Хуримтлагдсан үр дүн	2,143.6	2,943.3	799.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,072.9	1,020.4	-52.6
Нийт дүн	4,450.6	5,197.7	747.1

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилцэн төсвийн гүйцэтгэлд хэлсэн санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 747.1 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

Тухайн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 3,403.4 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 752.6 сая төгрөг буюу 28.4 хувиар өссөн байна.

Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн орлого /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	51.5	81.8	30.2	43.6
Татварын бус орлого	264.5	778.0	513.5	194.1
Тусламж санхүүжилтийн орлого	2,334.7	2,543.6	208.9	8.9
Нийт дүн	2,650.8	3,403.4	752.6	28.4

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайланд онд харьяа төсвийн байгууллагуудад олгосон нийт 700.2 сая төгрөгийн санхүүжилт, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн 23.3 сая төгрөгийн хөрөнгийн орлого, нийт 723.5 сая төгрөгийн хоорондын тооцооны орлогын гүйлгээг устгах бичилт хийж тохируулсан байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 2,656.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Үүнд:

Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	2,410.8	2,642.4	231.6	9.6
Үйл ажиллагааны бус зардал	0.9	13.8	12.9	1364.1
Нийт дүн	2,411.7	2,656.3	244.5	10.1

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ нь тэмцээн, уралдаан зохион байгуулахад 1.3 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан, нийт төсвийн зарцуулалтаар хэмнэлт гаргаж ажиллаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолтой нийцэхгүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд орон нутгийн орлогыг 69.6 сая төгрөгөөр төлөвлөж, 84.5 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулсан ба 14.9 сая төгрөгөөр буюу 21.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №9: Орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үйл ажиллагааны орлого	3.0	2.9	-0.1
2	Хөрөнгийн орлого	24.0	27.3	3.3
3	Хөрөнгө борлуулсны орлого	0.5	1.1	0.6
4	Шууд бус орлого	3.0	1.1	-1.9



Цагааннуур сумын төсвийн төвлөрөл, захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

5	Бууны татвар	0.6	0.7	0.1
6	Улсын тэмдэгтийн хураамж	1.5	1.9	0.4
7	Хог хаягдлын хураамж	3.1	3.1	0.0
8	Газрын төлбөр	1.4	0.8	-0.6
9	Газрын дуудлага худалдаа	1.5	1.5	0.0
10	Ойн нөөц ашигласны төлбөр	22.7	32.5	9.8
11	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	3.2	3.3	0.1
12	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	0.0
13	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.0	5.3	3.3
14	Торгуулийн орлого	3.0	2.7	-0.3
15	Бусад орлого		0.2	0.2
Дүн		69.6	84.5	14.9

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Тайлант онд сумын нийт орлого давж биелсэн боловч 4 төрлийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрөл бүрээр биелүүлээгүй мөн малын хөдөлгөөний төлөвлөгөөг төлөвлөж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хууль –ийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 110.7 сая төгрөгөөр төлөвлөж 133.5 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 22.8 сая төгрөг буюу 20.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	100.0	120.1	20.1
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2.1	1.8	-0.3
3	Газрын төлбөр	2.1	1.7	-0.4
4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	5.5	8.5	3.0
5	Зам ашигласны төлбөр	1.0	1.4	0.4
6	Нийт дүн	110.7	133.5	22.8

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймагт төвлөрүүлэх орлогыг түрээсийн орлогоос бусад бүх орлогыг нийт дүнгээр давуулан биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.3 сая төгрөгөөр төлөвлөж 5.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 0.5 сая төгрөг буюу 9.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2.1	2.2	0.1
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	2.4	2.4	0.0
3	Агаарын бохирдлын төлбөр	0.8	1.2	0.4
4	Нийт дүн	5.3	5.8	0.5

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аудитын илрүүлэлт:



Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд мэдсэн аудитаар орлогоотой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

Төсвийн төлөвлөлт

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төслийг төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд боловсруулж, дээд шатны төсөв захирагч нарт нэгтгэж хүргүүлээгүй байна. Зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа байгууллагуудын төсвийг авч хүргүүлсэн ба боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд нь аймгийн Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын 1 дүгээр хавсралттай нийцэхгүй бөгөөд төвлөрүүлэн захирагчийн төсвийн сахилга бат алдагдах, төсвийн жилийн дундуур төсөвт олон удаа тодотгол зохицуулалт хийх, үр ашиггүй зардал гарах, орлогыг үндэслэлтэй төлөвлөж чадахгүй байх гэх мэт сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Цагааннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 2,435.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,273.6 сая төгрөгийг урсгал зардалд, 162.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,737.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 124.0 сая төгрөгийг ОНХС-аас, 477.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 76.2 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 19.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Цагааннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 08 дугаар тогтоолоор ОНХС-ийн сангийн төсвийг 133.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг 1,781.2 сая төгрөг болгон нэмэгдүүлж, сумын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 6.6 сая төгрөгөөр бууруулан 69.6 сая төгрөг болгож баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл 2,326.1 сая төгрөг буюу 88.5 хувьтай байна. Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүйн улмаас 150.8 сая төгрөг, СХС-ийн журамд өөрчлөлт орж шинээр зээл олгоогүйн улмаас 42.3 сая төгрөгийн төсвийн гүйцэтгэл гараагүйтэй холбоотой байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 2,557.5 сая төгрөгөөр төлөвлөж, 2,522.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 98.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 42.4 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 38.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. СХС-ийн зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбосноор зээлийн эргэн төлөлт урьд онтой харьцуулахад нэмэгдсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 0.4 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 31.4 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 2.2 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 52.9 сая төгрөг, нийт 88.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан, 8 төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 21.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 4 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж байгаа боловч, татварын орлогын ногдуулалтыг хийж, орлогыг аккруэл сууриар бүртгэхгүй байгаагаас орлоготой холбоотой үүссэн өр, авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар орон нутгийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт, харьяа төсвийн байгууллагуудад илэрсэн зөрчилтэй холбоотой 3 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулга

Цагааннуур сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Цагааннуур сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Цагааннуур сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.4 Зөвлөмж

4.4.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 21.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 4 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын хэмжээнд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн ирүүлэх

4.4.2 Илрүүлэлт:

Эрүүл мэндийн төв нь оны эцэст үлдсэн төрийн сангийн данс дахь 12.3 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн данс дахь 1.2 сая төгрөг, нийт 13.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.7 дох “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн жилийн эцэст харьяа байгууллагуудын харилцах данс дахь үлдэгдлийн төвлөрүүлж, үлдэгдлийг тулган баталгаажуулж ажиллах

4.4.3 Илрүүлэлт:

Орон нутгийн орлогыг нэр төрөл бүрээр биелүүлээгүй мөн малын хөлийн татварын орлогыг төлөвлөж ажиллаагүй нь “Төсвийн тухай хууль”-ийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн орлогыг төлөвлөхдөө төсөвт төвлөрүүлэх боломжтой орлогыг орхигдуулахгүйгээр бүрэн хамруулан төлөвлөж, биелэлтийг нэр төрөл бүрээр хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цагааннуур сумын ЗДТГ	1	1.4							1	1.4
2	Цагааннуур сумын ЕБС	2	19.7							2	19.7
Дүн		3	21.1	0	0	0	0	0	0	3	21.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Цагааннуур сумын ЗДТГ	1	142.0					1	142.0		
	Цагааннуур сумын ЭМТ	1	0.3							1	0.3
Дүн		2	142.3					1	142.0	1	0.3
Нийт дүн		5	163.4					1	142.0	4	21.4

АУДИТЫГ ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Б.ТЭГШДЭЛГЭР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ

Л.МАНДАХНАРАН 11/24

ТЗ - заргаа

13.5 + 0